

БАТЛАВ
АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ ТӨХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Ш. БАЯНМӨНХ



БАТЛАВ
БЭХЭР ХХК-ИЙН
ЗАХИРАЛ Ц. ЦЭДЭНСОДНОМ



**БИЕИЙН ТАМИРЫН БОЛОН ТОГЛОЛТЫН ХУВЦАС ХУДАЛДАХ,
ХУДАЛДАН АВАХ ГЭРЭЭ**

Дугаар № 30/
2022

20²² оны 03-р сарын 18 өдөр

Улаанбаатар хот

Нэг талаас “Амгалан дулааны станц” Төрийн өмчит хувьцаат компани /цаашид “Захиалагч” гэх/-ийг төлөөлж Гүйцэтгэх захирал Ш.Баянмөнх нөгөө талаас Бэхэр ХХК-ийг төлөөлж захирал Ц.Цэдэнсодном /цаашид “Нийлүүлэгч” гэх/ нар Монгол Улсын Иргэний хуулийн 243-261 дүгээр зүйл, Монгол Улсын Засгийн Газрын 2021 оны 124 дүгээр тогтоол, Төрийн болон Орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1 дэх заалт, 2022 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг тус тус үндэслэн дараах зүйлүүдийг харилцан тохиролцож энэхүү гэрээг (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

Нэг. Гэрээгээр нийлүүлэх зүйл, нөхцөл

1.1. Нийлүүлэгч нь “**Биеийн тамирын болон тоглолтын хувцас**” (цаашид “бараа” гэх)-ыг энэхүү гэрээний салшгүй хэсэг болох хавсралтанд заасан барааг зориулалтын материалаар, тавигдсан шаардлага, нэр төрөл, тоо, хэмжээ, нэг бүрийн үнэ, загвар, стандартын дагуу чанарын өндөр түвшинд хийж Амгалан дулааны станц ТӨХК-ийн бараа хүлээн авах комисст хүлээлгэн өгнө.

Хоёр. Бараа нийлүүлэх хугацаа

2.1. Нийлүүлэгч нь барааг гэрээнд хоёр тал гарын үсэг зурж баталгаажсанаас хойш 45 /дөчин тав/ хоногийн дотор багтаан нийлүүлнэ.

Гурав. Үнэ төлбөрийн нөхцөл

- 3.1. Энэ гэрээний нийт үнэ 5,400,000 /таван сая дөрвөн зуун мянга/-н төгрөг бөгөөд үнийн дүнд гааль Онцгой албан татвар, Амгалан дулааны станц ТӨХК-ийн агуулахад хүргэх тээврийн зардал шингэсэн байна. /НӨАТ-гүй/
- 3.2. Гэрээт барааны үнийн дүнгийн 50 /тавь/ хувь буюу 2,700,000 /хоёр сая долоон зуун мянга/-н төгрөгийг гэрээ байгуулж гарын үсэг зурсанаас хойш ажлын 5/тавь/ хоногт нэхэмжлэлийн дагуу нийлүүлэгчийн Хаан банкны 5070273322 тоот дансанд шилжүүлнэ.
- 3.3. Гэрээт барааны төлбөрийн үлдэгдэл 50 хувь болох 2,700,000 /хоёр сая долоон зуун мянга/-н төгрөгийг гэрээт барааг бүрэн нийлүүлж дууссаны дараа, захиалагч бараа материалыг гэрээнд заасан нөхцөл, чанарын шаардлагыг хангасан гэж үзэж хүлээн авсан өдрөөр тасалбар болгон гэрээ дүгнэсэн акт

баталгаажсанаас хойш нэхэмжлэлийн дагуу 5 /тав/ хоногт багтаан нийлүүлэгчийн Хаан банкны 5070273322 тоот дансанд шилжүүлнэ.

Дөрөв. Талуудын хүлээх хариуцлага

- 4.1. Нийлүүлэгч нь гэрээний үүргээ зохих ёсоор биелүүлээгүй, хугацаандаа нийлүүлээгүй барааны нийт үнийн дүнгийн 0.1 хувьтай тэнцэх алдангийг захиалагчид хоног тутам төлөх ба нийт алдангийн дүн нь гэрээний нийт үнийн дүнгийн 10% -иас хэтрэхгүй байна.
- 4.2. Захиалагч нь барааны бүрэн бүтэн байдал, үзүүлэлт, шаардлагад тохирч байгаа эсэхийг шалган үзээд хүлээн авсаны дараа гэрээнд заасан хугацаанд тооцоо хийх, төлбөрийн хугацааг хожимдуулбал хожимдсон хоног тутамд хүлээгдэж байгаа төлбөрийн 0.1 хувьтай тэнцэх алдангийг Нийлүүлэгчид төлөх ба алдангийн дүн нь гэрээний хүлээгдэж байгаа төлбөрийн үнийн дүнгийн 10% хувиас хэтрэхгүй байна.
- 4.3. Барааг Амгалан дулааны станц ТӨХК-ийн агуулахад ирсэний дараа тус компанийн бараа хүлээн авах комисс шаардлага хангаж байгааг тогтоосон тохиолдолд барааг хүлээн авна. Барааг шаардлага хангаагүй тохиолдолд буцаана.
- 4.4. Захиалагчийг төлөөлж гэрээний хэрэгжилттэй холбоотой асуудлыг Амгалан дулааны станц ТӨХК-ийн Урлаг, спорт хариуцсан зохион байгуулагч Ш.Отгонбаярмаа хариуцан ажиллана. Утас- 99197679.
- 4.5. Нийлүүлэгчийг төлөөлж гэрээтэй холбоотой асуудлыг Бэхэр ХХК-ийн захирал Ц.Цэдэнсодном хариуцан ажиллана. Утас- 89508866.

Тав. Захиалагчийн эрх, үүрэг

- 5.1. Захиалагч тал нийлүүлэгчид үүргээ биелүүлэхэд шаардагдах бичиг баримт болон /загвар, тоо, хэмжээ, өнгө материалаа сонгон/ мэдээллийг өгөх.
- 5.2. Нийлүүлэлтийг хянаж, ямар нэгэн доголдол байвал засвар хийлгэх, солиулах эрхтэй.
- 5.3. Гэрээнд дурдсан тоо хэмжээг өөрчлөх нэмэх буюу хасагдах нөхцөлд нийлүүлэгчид мэдэгдэнэ.
- 5.4. Барааг хүлээн авсанаас хойш гэрээний хугацаанд төлбөрийг нийлүүлэгчид төлөх үүрэгтэй.

Зургаа. Нийлүүлэгчийн эрх, үүрэг

- 6.1. Захиалагчийн өгсөн загвар, тоо, хэмжээ, өнгө, захиалсан чанартай материалаар оёж өгөх үүрэгтэй ба тогтоосон хугацаанд нийлүүлж засвар хийхээр бол өөрийн зардлаар засаж өгнө.
- 6.2. Захиалагч барааг хугацаандаа хүлээн авах үүргээ биелүүлээгүй бол барааг хүлээн авсанд тооцож төлбөр төлөхийг захиалагчаас шаардах эрхтэй.
- 6.3. Нийлүүлэгч нь нийлүүлсэн барааг ашиглаж эхэлсэн өдрөөс хойш 1 сарын баталгаа гаргана. Нийлүүлэгчийн үйл ажиллагаатай холбогдон баталгаат хугацаанд гарсан үйлдвэрийн алдаа, доголдлыг өөрийн зардлаар засаж залруулах үүрэгтэй.
- 6.4. Нийлүүлсэн бараанд ямар нэгэн дутагдал, шаардлагад нийцээгүй бараа илэрвэл дутагдлыг арилгаж өгөхийг Захиалагч шаардах ба нийлүүлэгч шаардлагыг биелүүлэх үүрэгтэй.

Долоо. Бараа бүтээгдэхүүний чанар, сав, баглаа, боодол

- 7.1. Нийлүүлэгчийн бараа нь Монгол улсын стандарт шаардлагыг бүрэн хангасан байна.
- 7.2. Бараа нь тээвэрлэлтийн үед норох, бохирдохоос хамгаалагдсан сав, баглаа боодолтой байна.
- 7.3. Барааг захиалагчид хүлээлгэн өгөх үед энэхүү гэрээгээр тодорхойлсон шинж чанарт нийцэж байвал зохих бөгөөд цаашид өнгө үзэмж, зориулалтын дагуу ашиглах хугацаанд чанараа алдахгүй байх ёстой.

Найм. Бараа хүлээн авах

- 8.1. Нийлүүлэгч нь барааг Улаанбаатар хотын Амгалан дулааны станц ТӨХК-ийн агуулахад бараа хүлээн авах комисст хүлээлгэн өгнө.
- 8.2. Нийлүүлэгч нь барааг Захиалагчид хүлээлгэн өгөх хүртэлх бүх зардлыг хариуцна.

Ес. Давагдашгүй хүчин зүйл

- 9.1. Гэрээг хэрэгжүүлэх явцад улс төрийн хориг, байгалийн гамшиг, хорио цээр тогтоох, цэргийн үймээн, төрийн эргэлт, ажил хаялт болон бусад нөхцлүүд бий болсноос үүдэж гэрээний нөхцлүүд хэсэгчилэн болон бүрэн биелээгүй тохиолдолд хоёр талын аль нь ч хариуцлага хүлээхгүй.
- 9.2. Давагдашгүй хүчин зүйлийн нөхцөлүүд гарч эхэлсэн тохиолдолд 10 хоногийн дотор талууд бие биедээ бичгээр мэдээлж цаашид хэрхэн ажиллах талаар зөвшилцөнө.

Арав. Гэрээг цуцлах үндэслэл

- 10.1. Нийлүүлэгч нь бараа нийлүүлэх хугацааг энэхүү гэрээнд зааснаас 30 хоног хэтрүүлсэн тохиолдолд Захиалагч гэрээг цуцлах тухай мэдэгдлийг нийлүүлэгчид албан ёсоор бичгээр өгнө. Нийлүүлэгч уг мэдэгдлийг хүлээн авснаас хойш 5 хоногийн дотор зохих хариуг өгч тодорхой арга хэмжээ аваагүй тохиолдолд захиалагч гэрээг цуцлана.
- 10.2. Нийлүүлэгч энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ удаа дараа буюу ноцтой зөрчсөнөөс бусад тохиолдолд Захиалагч энэхүү гэрээний үйлчлэлийг дуусахаас өмнө тасалдуулахгүй.

Арван нэг. Бусад нөхцөл

- 11.1. Талуудын аль нэг нь нөгөөдөө гэрээтэй холбогдох мэдээлэл солилцох тохиолдолд мэдээллийг авсан тал хуанлийн 10 хоногт багтаан нөгөө талдаа тавьсан асуудлаар тодорхой хариу өгнө.
- 11.2. Талууд аль нэгнийхээ зөвшөөрөлгүйгээр энэхүү гэрээг гурав дахь талд шилжүүлэхийг хориглоно.
- 11.3. Гэрээг монгол хэл дээр 4 хувь үйлдэж, Захиалагч 3 хувийг Нийлүүлэгч 1 хувийг авах бөгөөд хувиуд ижил тэгш хүчинтэй.
- 11.4. Гэрээг хоёр тал зөвшөөрсөн тохиолдолд сунгаж болно.
- 11.5. Гэрээнд хоёр тал гарын үсэг зурсан өдрөөс хүчин төгөлдөр болно.
- 11.6. Гэрээнд талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр бичгээр үйлдсэн гэрээний хэлбэрээр нэмэлт өөрчлөлт оруулж болох бөгөөд нэмж засварласан эх хувьд баллаж засварласан буюу гараар нэмж бичсэн болон бусад энгийн аргаар хийсэн оруулга засвар нэмэлт бичилтийг хүчинтэйд тооцохгүй.

11.7.Энэхүү гэрээнд шууд заагаагүй бусад аливаа асуудлыг Монгол улсын хүчин төгөлдөр мөрдөж байгаа хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.


ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ ТӨХК-ИЙН
СЭЗХ-ИЙН ДАРГА БӨГӨӨД ЕРӨНХИЙ
НЯГТЛАН БОДОГЧИЙН АЖИЛ ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Ө. УДВАЛ

Гарын үсэг: 

ХАНГАМЖИЙН ХЭЛТСИЙН ДАРГА
Г. ЭРДЭНЭБИЛЭГ

Гарын үсэг: 

ЗАХИРГАА УДИРДЛАГЫН
ХЭЛТСИЙН ДАРГА

Б. ГАН-ОЧИР

Гарын үсэг: 

ХУУЛИЙН МЭРГЭЖИЛТЭН

Г. САРУУЛ

Гарын үсэг: 

ГЭРЭЭ БОЛОВСРУУЛСАН :
ХАНГАМЖИЙН МЭРГЭЖИЛТЭН

Ш. ГАНТУЛГА

Гарын үсэг: 

Хаяг: Монгол улс, Улаанбаатар
хот, Баянзүрх дүүрэг, 8-р хороо, УС-15-1-1
Утасны дугаар: 77111251
РД: 6021646

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

БЭХЭР

ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц. ЦЭДЭНСОДНОМ

Гарын үсэг: 



Хаяг: УБ хот ХУД 2-р хороо 5-р байр
Утас: 89508866
РД: 5920116